

НИЙСЛЭЛИЙН СПОРТЫН ХОРООНЫ БИЕИЙН ТАМИРЫН ХӨГЖЛИЙН ХЭЛТСИЙН
2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2020 оны 12 дугаар сарын 25

Улаанбаатар хот

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. “БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ- ҮР ДҮН”:

а/ “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал–2030” хэрэгжилт 100%

Зорилт 3. “Зонхилон тохиолдох халдварт бус өвчин, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлийн тархалт болон сэргийлж болох нас баралтыг хувь хүн, гэр бүл, хамт олон, байгууллагын идэвхтэй, оролцоотой нэгдмэл үйл ажиллагаанд тулгуурлан бууруулна.” ажлын хүрээнд

1. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын Сайд, Эрүүл мэндийн Сайдын хамтарсан 2019 оны А/178, А/144 дүгээр тушаалаар Иргэдийн идэвхтэй хөдөлгөөн, биеийн тамир, спортоор хичээллэх үйлчилгээ үзүүлж буй байгууллагын магадлан итгэмжлэлийн үнэлгээ хийх журмыг батлан хэрэгжүүлж эхлүүлснээр нийслэлийн хэмжээнд 2020 оны байдлаар магадлан итгэмжлэлийн хараат бус 16 шинжээч ажиллаж байгаа бөгөөд нийслэлийн хэмжээнд 15 спорт клуб магадлан итгэмжлэгдсэн байна.


Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2019 оны 19 дүгээр тогтоолын 01 дүгээр хавсралтаар “Эрүүл мэндийн даатгалын сан”-гаас урамшуулал олгох журмыг баталсан.

Ингэснээр магадлан итгэмжлэгдсэн спорт клубд хичээллэж буй иргэдэд эрүүл мэндийн даатгалын сангаас 1 удаа 60.000 төгрөгийн хөнгөлөлт олгох боломж бүрдсэн.

2. Дүүргүүдийн хороодыг биеийн тамирын арга зүйчтэй болгох саналыг Биеийн тамир, спортын тухай хуульд тусгуулж, хэрэгжүүлэх заалтыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2021-2025 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгасан.

3.2.56-2. Бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох үйл ажиллагаанд хамрагдалтыг урьд оноос 7 хувиар, сорилын үзүүлэлтийн түвшинг 1.0 хувиар нэмэгдүүлэх

Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит “Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил”-ыг нийслэл, дүүргийн хэмжээнд жил бүр 2 удаа /хавар, намрын улиралд/ зохион байгуулж, 2017 оны хамрагдалтын хувь урьд оноос 1.2%, сорилын үзүүлэлтийн түвшинг 0.4%; 2018 оны хамрагдалтын хувь урьд оноос 1.4%, сорилын үзүүлэлтийн түвшинг 0.6%; 2019 оны хамрагдалтын хувь урьд оноос 1.5%-иар нэмэгдэж, сорилын үзүүлэлтийн түвшинг 0.7%-тай гарч байна.



Дэлхий нийтэд тархаад байгаа “Covid-19” цар тахал буюу коронавирусаас урьдчилан сэргийлэх зорилгоор гаргасан Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн “Шинэ коронавирусийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 30 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2020 оны “Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” А/108, “Коронавируст /Ковид-19/ цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай” А/1241 дүгээр захирамжуудаар олон нийтийг хамарсан спортын арга хэмжээ зохион байгуулахыг хориглосон тул энэ жилийн хавар, намрын хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил авах арга хэмжээг зохион байгуулаагүй болно.



з, к, л. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4-80-4-99, нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 4.4.1-4.4.9-д тусгагдсан заалтууд - Хэрэгжилт 94,7%

4.4.3-4.4.4. “Улаанбаатар Марафон”, “Нийслэлийн иргэдийн спортын IX наадам”, “Мөнгөн Улаанбаатар өвлийн наадам” зэрэг томоохон арга хэмжээнүүд дэлхий нийтэд тархаад байгаа “Covid-19” цар тахал буюу коронавирусаас урьдчилан сэргийлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн “Шинэ коронавирусийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 30 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2020 оны “Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” А/108, “Коронавируст /Ковид-19/ цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай” А/1241 дүгээр захирамжуудаар олон нийтийг хамарсан спортын арга хэмжээ зохион байгуулахыг хориглосон тул зохион байгуулагдаагүй болно.

1. Мөнгөн Улаанбаатар арга хэмжээ:

Нийслэлийн хүн амыг биеийн тамир, спортын үйл ажиллагаанд татан оролцуулах, өвлийн спортын үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/32 дугаар захирамжийн хүрээнд “Мөнгөн Улаанбаатар” өвлийн спортын наадмын нээлт “Цасны баяр”-ын арга хэмжээг 2020 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр Хандгайтын “Янзага зуслан”-д зохион байгуулахаар бэлтгэл ажлыг бүрэн хангаж, 14.244.000 /арван дөрвөн сая хоёр зуун дөчин дөрвөн мянга / төгрөгийг “Зүйн хойд Азийн бизнес, аялал жуулчлал, соёл, санхүүгийн төв болох арга хэмжээний зардал”-аас гаргасан боловч дэлхий нийтэд тархаад байгаа “Covid-19” цар тахал буюу коронавирусаас урьдчилан сэргийлэх зорилгоор гаргасан Нийслэлийн Засаг даргын 2020 оны “Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” А/108 дугаар захирамжаар биеийн тамир, спортын арга хэмжээг зохион байгуулахыг хориглосон тул 2020 оны 4 дүгээр улиралд зохион байгуулахаар төлөвлөсөн болов ч /Ковид-19/ дахин манай улсад дэгдсэнтэй холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2020 оны “Коронавируст /Ковид-19/ цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай” А/1241 дүгээр захирамжуудаар олон нийтийг хамарсан спортын арга хэмжээ зохион байгуулахыг хориглосон тул энэ онд зохион байгуулагдаагүй болно.

4.4.5. Идэвхтэй хөдөлгөөнд суурилсан явган аялал, алхалт гүйл, иог, фитнесээр хичээллэх иргэдийн орчин нөхцөлийг бүрдүүлж бодлогоор дэмжинэ. Хэрэгжилт 100%

1. "Дөрвөн хайрханаа дээдэлье" эко явган аяллыг Нийслэлийн хэмжээнд 8 удаа зохион байгуулж 223 байгууллагын 4683 иргэд хамрагдсан.



2. Нийслэлийн иргэдийн дархлааг сайжруулах, биеийн тамирын дасгал хөдөлгөөнийг тогтмол хийж хэвшүүлэх зорилгоор Нийслэл дүүргийн Биеийн тамир, спортын хороодын ажилтан, албан хаагчдын дунд Эрүүл мэндийн дасгал хөдөлгөөн, явган аяллын дадлага, сургалтыг 2020 оны 09 дүгээр сарын 12-13-ны өдрүүдэд “Улаанбаатар-Баянзүрх товчоо-Тэрэлжийн “Тэнгэр ресорт”- чиглэлд зохион байгуулж, 9 дүүргийн спорт хорооны 123 ажилтан, албан хаагчид хамрагдлаа.

3. “Ковид-19”-ийн эсрэг иргэдийн эрүүл мэндийг бэхжүүлж, бие бялдрыг идэвхтэй дасгал хөдөлгөөнөөр чийрэгжүүлэх, дархлааг дэмжих, нийтийн эзэмшлийн талбайд дасгал хөдөлгөөн өрнүүлэх зорилгоор 2020 оны 07 дугаар сарын 31-ний өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн хооронд Нийслэлийн 9 дүүрэгт 32 байршилд иргэдийн дунд хөлбөмбөг, хийн болон аэробик гимнастикийн дасгал, бүжгийн сургалтууд болон “өглөөний дасгал”-ыг зохион байгуулж 63 хорооны 16.000 иргэдийг хамруулсан.



4. Нийслэлийн иргэдэд унадаг дугуйн ач холбогдлыг сурталчлан таниулах, дугуйн спортоор хичээллэгчдийн тоог нэмэгдүүлэх зорилгоор Нийслэлийн Засаг даргын нэрэмжит “Дугуйн өдөр”-ийн үйл ажиллагааг 2020 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 09:00 – 17:30 цагийн хооронд Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Спортын хороо, Монголын Дугуйн холбоо хамтран 4 дэх жилдээ дугуйн парад болон уулын дугуйн, замын дугуйн тэмцээн, экстрем дугуйн тэмцээнүүдийг 5-наас эхлэн олон насны ангилалаар зохион байгуулж 500 гаруй иргэдийг хамруулсан.



Дугуйн парадыг 11:00-11:30 цагийн хооронд Үндэсний цэцэрлэгт хүрээлэн дэх дугуйн замд зохион байгуулж иргэд, дугуй сонирхогч болон мэргэжлийн дугуйчид оролцлоо.

Сонирхогчдын болон мэргэжлийн дугуйчдын тэмцээнийг олон насны ангилалаар зохион байгуулж, 27 байгууллагын 100 гаруй иргэд, сонирхогчид болон мэргэжлийн дугуйчид оролцлоо.



Дээрх үйл ажиллагааг MNB Sport суваг, UBS, MNC телевиз сурвалжилж, “Эхлэх цаг Тэмүүлэл” ХХК “Хамтран ажиллах гэрээ”-ний дагуу бүтэн бичлэг хийж 30 минутын нэвтрүүлэг бэлтгэн 2020.11.05-ны өдөр МҮОНР телевизийн олон нийтэд хүргэсэн.



ХОЁРДУГААР БҮЛЭГ. “ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН” 100%

а. Дээд шатны байгууллагын тогтоол шийдвэрийн 2020 оны жилийн эцсийн байдлаар хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн баримт бичгийн 5 төрлийн /Монгол Улсын хууль, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгавар/ 42 заалтын биелэлт 100%-тай хэрэгжсэн бөгөөд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 100 хувьтай буюу бүрэн хэрэгжсэн гэж үнэллээ.

Үүнд:

1. Биеийн тамир, спортын тухай хууль – 1-100%
2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг - 2 – 100%
3. Засгийн газрын тогтоол - 14 – 100%
4. Засгийн газрын албан даалгавар - 1 – 100%
5. НИТХ-н тэргүүлэгчдийн тогтоол - 1 – 100%-тай хэрэгжүүлээ.

Мөн Нийслэлийн Засаг даргын захирамж-17, Нийслэлийн Онцгой комиссын хурлын тэмдэглэл-3, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэл-3 тус тус www.monitoring.ub.gov.mn программд улирал тутам биелэлтийг оруулж ажилласан бөгөөд жилийн эцсийн байдлаар 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдөр шивж оруулсан.

Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөний биелэлтийг шуурхайн өмнөх долоо хоногийн Пүрэв гаригт программд оруулж байгаа бөгөөд 2020 оны жилийн эцсийн байдлаар нийт 11 удаагийн үүрэг даалгаврын биелэлтийг оруулсан. Хэрэгжилт 100%

Биеийн тамир, спортын талаарх эрх зүйн актуудын мэдээсайтад тухай бүр нь оруулж ажилласан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Мод тарих үндэсний өдөр зарлах тухай” 2010 оны 63 дугаар зарлигийн дагуу Ойн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэхь заалтын дагуу 2020 оны 05, 10 дугаар сарын 2 дахь 7 хоногийн хагас бүтэн сайн өдрүүдэд тохиож, гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан иргэдийн бөөгнөрөл үүсгэхийг хориглосон тул тогтоосон дэглэмийг зөрчилгүй албан хаагчид өөрийн эзэмшил газарт болон хашаандаа мод тарьж, арчилгаа усалгааг хийж ажиллаа.

Биеийн тамир, спортын талаарх эрх зүйн актуудын мэдээллийг сайтад тухай бүр нь оруулж ажилласан.

б. Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/01 дүгээр захирамжийн дагуу 2020 оныг “Нэг хот – Нэг стардарт” жил болгон зарласантай холбогдуулан захирамж, төлөвлөгөө, өөрийн чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлсэн ажлын талаарх мэдээллийг байгууллагын www.sport.ub.gov.mn сайтад тухай бүр нь байршуулж олон нийтэд сурталчилан ажилласан.

“Нэг хот-Нэг стандарт” зорилтот жилийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 3 зорилт 17 үйл ажиллагааг тусган хэрэгжүүлсэн.

Хэрэгжилтийг биелэлтийг улирал бүр гаргаж Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн бөгөөд жилийн эцсийн байдлаар 95%-тай хэрэгжсэн байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. “БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН”: /Хэрэгжилт-100%/

а/ байгууллагын дүрмээр хүлээсэн үүргийн хэрэгжилттэй холбоотой мэдээлэл.

-Нийслэлийн спортын хороо /2017-2020/-ны үйл ажиллагааны дунд хугацааны стратеги төлөвлөгөө, “Биеийн тамир, спортын тухай хууль”-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, МУ-д биеийн тамир, спортыг хөгжүүлэх бодлого, цогц хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, “Халдварт бус өвчинтэй тэмцэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, “Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 05 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, Байгууллагын ил тод байдлыг хангах, шилэн дансны хуулийг хэрэгжүүлэх төлөвлөгөө, Зорилтот жилийн хүрээнд хийгдэх ажлын төлөвлөгөө болон гадаад арга хэмжээний төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг ханган ажилласан.

Нийслэлийн спортын хорооноос 8 биеийн тамирын арга хэмжээ зохион байгуулж 581 байгууллагын 2890 иргэдийг хамруулан, Улсын төсвөөс 12.860.000 төгрөг, Зүүн хойд Азийн бизнес, аялал жуулчлал, соёл, санхүүгийн төв болох арга хэмжээ хөгжүүлэх хөтөлбөрийн зардлаас 29.900.000 төгрөг, нийт 42.760.000 төгрөгийг зарцуулсан байна.

Нийслэл, дүүргийн хэмжээнд 172 биеийн тамирын арга хэмжээ зохион байгуулж 2961 байгууллагын 58.310 иргэдийг хамруулан, Улсын төсвөөс 110.660.550 төгрөг, нийслэл дүүргийн орон нутгийн төсвөөс 76.427.500 төгрөг бусад төсөв 33.830.000 төгрөг, нийт 220.918.050 төгрөгийг зарцуулсан байна.

Нийслэлийн шилдэг биеийн тамир, спортын хамтлаг шалгаруулах арга хэмжээ

Нийтийн биеийн тамир, спортын үйлчилгээг иргэдэд хүргэх загвар бүтцийн дагуу байгууллага, аж ахуйн нэгжүүдэд биеийн тамир, спортын хамтлагийг байгуулан ажиллаж байна.

2020 оны жилийн эцсийн байдлаар нийт 795 хамтлаг үйл ажиллагаа явуулж байна. Тус хамтлагуудаас 2019 оны үйл ажиллагаагаар тэргүүлсэн хамтлагуудыг хоёр ангиллаар нийт 10 байгууллагыг шалгаруулж Нийслэлийн Засаг даргын нэрэмжит шагналаар шагнаж урамшуулав.

Нийслэлийн харьяа байгууллагуудаас:

- 1.Ус сувгийн Удирдах газрын биеийн тамир, спортын хамтлаг
- 2.Нийслэлийн Онцгой байдлын биеийн тамир, спортын хамтлаг
- 3.Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газар биеийн тамир, спортын хамтлаг
- 4.Улаанбаатар хотын замын хөдөлгөөний удирдлагын төв биеийн тамир, спортын хамтлаг

- 5.Нийслэлийн цагдаагийн удирдах газар биеийн тамир, спортын хамтлаг

- 6.Монголын хүүхдийн урлан бүтээх төв

Дүүргийн харьяа байгууллагуудаас:

- 1.Баянгол дүүргийн ЕБ-ийн 70-р сургуулийн биеийн тамир, спортын хамтлаг
- 2.Налайх дүүргийн 140-р цэцэрлэг биеийн тамир, спортын хамтлаг
- 3.Сонгинохайрхан дүүргийн 110-р цэцэрлэгийн биеийн тамир, спортын хамтлаг
- 4.Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн төвийн биеийн тамир, спортын хамтлаг



Нийслэлийн 381 жилийн ойд зориулсан бөхийн барилдаан

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хүрээнд Нийслэлийн түүхт 381 жилийн ойд зориулсан улс, аймгийн 256 бөхийн барилдааныг 2020 оны 10 дугаар сарын 29-ний өдөр Монгол бөхийн өргөөнд зохион байгууллаа.

Нийслэлийн өдөрт зориулан уламжлал болгон зохион байгуулагддаг тус барилдаанд 256 бөх авхаалж самбаа, хурд хүчээ сорин барилдсанаас Архангай аймгийн цэнхэр сумын

харьяат Бөхбилэгт дэвжээний бөх, улсын шинэ заан М.Бадарч 8 даван түрүүлж, Төв аймгийн Баянчандмань сумын харьяат, Дүнжингарав дэвжээний бөх аймгийн хурц арслан Э.Ууганбаяр 7 давж үзүүрлэв.



Харин Их шөвөгт Ховд аймгийн Зэрэг сумын харьяат, Ховд дэвжээний бөх, улсын харцага Б.Бат-Өлзий, Хөвсгөл аймгийн Их-Уул сумын харьяат, Хөвсгөлийн Хүчтэн дэвжээний бөх, улсын начин Б.Даваа-Очир нар шалгаран мөнгөн шагнал, өргөмжлөл, медалиар шагнагдлаа.

Мөн дунд шөвөгт Улсын начин Б.Ганхуяг, Аймгийн хурц арслан Б.Сүхбат, Аймгийн арслан О.Наранбаатар, Аймгийн заан М.Лхагвагэрэл нар шалгарч мөнгөн шагналаар шагналаа.



БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ЧИГЛЭЛЭЭРХ ЧАДАВХЖУУЛАХ СУРГАЛТ:

Нийслэл, дүүргийн биеийн тамир, спортын хороодоос 2020 онд нийт 46 сургалт, семинар зохион байгуулж 1.020 байгууллагын 12.423 хүнийг хамруулж, улсын төсвөөс 14.450.500 төгрөг зарцуулсан байна.

Цэцэрлэгийн багш арга зүйч нарын сургалт:

Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг цэцэрлэгийн багш, арга зүйчдийн ур чадварыг дээшлүүлэх “Идэвхтэй хөдөлгөөн - Эрүүл мэнд” сэдэвт сургалт, семинарыг 2020 оны 01 дүгээр сарын 20-24-ний өдрүүдэд Нийслэлийн Засаг захиргааны V байрны “Иргэний

танхим”, Үндэсний биеийн тамирын дээд сургуулийн спорт зааланд зохион байгуулж Нийслэлийн 9 дүүргийн 200 цэцэрлэгийн 320 багш, арга зүйч оролцлоо.

Цэцэрлэгийн хүүхдүүдийн уран хөдөлгөөнт гимнастикийн заавал хийх дасгал, эрүүл мэндийн хийн 8 тоот дасгалыг зааж, сургалт, семинарт оролцсон багш арга зүйчдэд бага насны хүүхдийн бие бялдрын хүмүүжлийн ажлыг зохион байгуулах талаар заавар зөвлөгөө өгч, CD, гарын авлага сертификат гардуулсан.

Мөн Нийслэлийн шилдэг биеийн тамир, спортын хамтлаг ХУД-ийн 35-р цэцэрлэгийн бие бялдрын боловсролын сургалт хүмүүжлийн ажилтай танилцаж туршлага судлах ажлын зохион байгууллаа.



Ерөнхий боловсролын сургуулийн багш нарын сургалт:

Нийслэлийн Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын бие бялдыг чийрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх, багш, арга зүйчдийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор “Идэвхтэй хөдөлгөөн - Эрүүл мэнд” сэдэвт сургалт, семинарыг 2020 оны 01 дүгээр сарын 27-31-ний өдрүүдэд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын заал болон Иргэний танхимд зохион байгуулж 120 сургуулийн 160 багш хамрагдлаа.

Оролцсон багш, арга зүйчдэд Ерөнхий боловсролын сургуулийн бага дунд ангийн сурагчдийн уран хөдөлгөөнт гимнастикийн заавал хийх хөтөлбөрт дасгалыг 2020 онд шинэчлэн зааж, хүүхдийн бие бялдрын хүмүүжлийн ажлыг зохион байгуулах заавар зөвлөгөө өгч, CD, гарын авлага, сертификат гардууллаа.



“Эрүүл ажлын байр-эрүүл амьдралын хэв маяг” сэдэвт биеийн тамир, спортын хамтлагийн сургалт

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын биеийн тамир, спортын хамтлагийн ахлагч, арга зүйч нарт зориулж “Эрүүл ажлын байр-Эрүүл амьдралын хэв маяг” сэдэвт сургалт семинарыг 2020 оны 10 дугаар сарын 19-ний өдөр Нийслэлийн Засаг захиргааны V байрны “Иргэний танхим”-д зохион байгууллаа.

Сургалт семинарт 74 байгууллагын 100 биеийн тамир, спортын хамтлагийн ахлагч, арга зүйчид хамрагдлаа.



Хийн дасгал, аэробикийн дасгалын сургалт

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг нийгмийг 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх зорилгоор Нийслэлийн 8 дүүргийн нутаг дэвсгэрт хийн дасгал, аэробикийн дасгалын сургалтуудыг 2020 оны 10 дугаар сарын 26-наас 2020 оны 11 дүгээр сарын 04-ний өдрүүдэд 10 хоног зохион байгуулж 93 хорооны 634 иргэдийг хамрууллаа.

Сургалтад оролцсон иргэдэд Нийслэлийн иргэдийн спортын наадмын 21-54 насны оролцогчдод зориулсан аэробикийн ‘Тэмүүлэл’ дасгал, хийн 8 тоот дасгал, 55-аас дээш насны оролцогчдод зориулсан аэробикийн ‘Төгөлдөр’ дасгал, хийн 8 тоот дасгалуудыг зааж сургаж, зөвлөгөө өглөө.



б/ Хүний нөөц Хэрэгжилт 100%

Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/241 дүгээр захирамжаар Нийслэлийн Спортын хороо 2 хэлтэс, 16 хүний бүрэлдэхүүнтэй байхаар орон тооны хязгаарыг баталсны дагуу албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн “Зөвшөөрөл олгох тухай” 104 дүгээр тогтоолоор батлуулсан.

2020 онд Дарга-1, хэлтсийн дарга-2, төрийн захиргааны албан хаагч-6, төрийн үйлчилгээний албан хаагч-1 гээд 10 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явууллаа.

Тус тогтоолын дагуу байгууллагын даргын 2020 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн А/11 дүгээр тушаалаар төрийн захиргааны 13 албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг баталж шинээр үүссэн 4 сул орон тоог нөхөн бүрдүүлэх зорилгоор нийтэд нээлттэй зарлаад байна.

Спортын барилга байгууламж, хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтний албан тушаалыг түр орлон гүйцэтгэж байсан Б.Оюунтуяа төрийн албаны тусгай шалгалт өгч тэнцсэн тул тус албан тушаалд Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлийн 2020 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 41 дүгээр тогтоолыг үндэслэн байгууллагын даргын 2020 оны Б/22 дугаар тушаалаар томилон ажиллуулсан.

Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах үүрэг бүхий удирдах албан тушаалтнуудын мэдүүлгийг 2020 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс өмнө буюу хуулийн хугацаанд гаргуулан баталгаажуулсан.

Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах үүрэг бүхий удирдах албан тушаалтнуудын мэдүүлгийг 2020 оны 02 дугаар сарын 15-ны өдрөөс өмнө буюу хуулийн хугацаанд гаргуулан баталгаажуулсан.

Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг 2020 онд хэрэгжүүлэх ажлын 2 зорилт бүхий 5 үйл ажиллагааны төлөвлөгөөг 2020 оны 02 дугаар сарын 05-ны өдөр байгууллагын даргаар батлуулж, хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр гаргаж Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлд хүргүүлсэн. Хэрэгжилт 94 хувь.

Даргын дэргэдэх Удирдлагын зөвлөл нь хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт болон байгууллагын үйл ажиллагааны талаар нийт 17 удаа хуралдсан.

Биеийн тамирын хөгжлийн хэлтсийн “ААНБ дахь биеийн тамир чийрэгжүүлэлтийн асуудал хариуцсан мэргэжилтэн”, “Оюутан залуучууд-тусгай мэргэжлийн болон их, дээд сургууль дахь биеийн тамирын асуудал хариуцсан мэргэжилтэн”, “Ахмад, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, гэр бүл, орон нутгийн нэгж, дүүрэг, хороо, хэсэг дэх биеийн тамирын асуудал хариуцсан мэргэжилтэн”, “Тогтоол шийдвэр, тайлан мэдээ хариуцсан мэргэжилтэн”, Спортын хөгжлийн хэлтсийн “Мэдээлэл технологи, олон нийттэй харилцах асуудал хариуцсан мэргэжилтэн” эдгээр албан тушаалыг Э.Мөнх-Эрдэнэ, Г.Бямбасайхан, Б.Солонго, Н.Өлзийжаргал, Б.Оюунтуяа нарт түр орлон гүйцэтгүүлсний 40 хувийн нэмэгдэл цалинг тус тус олгож ажилласан.

Байгууллагын даргын 2020 оны “Албан хаагчдын цалин хөлсийг шинэчлэн тогтоох тухай” А/12 дугаар тушаалаар 5 албан хаагчийн цалингийн шатлалыг ахиуллаа.

Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг улирал бүр үнэлж нэгдүгээр улиралд 7, хоёрдугаар улиралд 7, гуравдугаар улиралд 7, дөрөвдүгээр улиралд 9 албан хаагчид хангалттай үнэлэгдсэн бөгөөд тус албан хаагч тус бүрт үндсэн цалингийн 40%-аар урамшуулал цалин нийт 9.848.938 /есөн сая найман зуун дөчин найман мянга есөн зуун гучин найм/ төгрөгийг олгосон байна.

Хүүхдийн эрхийг хамгаалах өдөр байгууллагын нийт 14 албан хаагчдын хүүхэд, гэр бүлд байгууллагын даргын 2020 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн А/15 дугаар тушаалаар 700.000 төгрөгийн үнэ бүхий гарын бэлэг гардуулсан.

Сонгинохайрхан дүүргийн Биеийн тамир, спортын хорооны дарга Ц.Ганхүүд Нийслэлийн спортын хорооны даргын 2020 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн Б/10 дугаар тушаалаар эмчилгээний зардалд нэг удаагийн буцалтгүй тусламж болох 300.000 /гурван зуун мянган/ төгрөг, Тогтоол шийдвэр, тайлан мэдээ хариуцсан мэргэжилтэн А.Намуунд дотоод журмын дагуу байгууллагын даргын 2020 оны Б/17 дугаар тушаалаар нэг удаагийн буцалтгүй тэтгэмж 110.000 /нэг зуун арван мянга/ төгрөг, Гэр хороололд амьдран суудаг мэргэжилтэн Э.Мөнх-Эрдэнэд байгууллагын даргын 2020 оны 12 дугаар сарын 01-ний Б/24 дүгээр тушаалаар түлээ нүүрсний тэтгэмж 60.000 /жаран мянган/ төгрөгийг тус тус олгосон байна.

Манай байгууллагад ажиллаж байгаад өндөр настны тэтгэвэрт гарсан ахмадуудыг байгууллагын даргын 2020 оны А/20 дугаар тушаалын дагуу 2020 оны 10 дугаар сарын 01-

ний өдөр хүлээн авч хүндэтгэл үзүүлж, гарын бэлэг гардуулах үйл ажиллагааг зохион байгуулж 600.000 /зургаан зуун мянган/ төгрөг зарцууллаа.



Монгол Улсад спортын байгууллага байгуулагдсаны 100 жилийн ойг угтан Нийслэлийн иргэн ахмад тамирчин Жадамбаагийн Одгийв гуай “Сэлэнгэ аймгийн Шаамар сумаас-Улаанбаатар хот” хүртлэх 300 км гүйхэд хорооны даргын 2020 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн Б/21 дүгээр тушаалаар 150.000 /нэг зуун тавин мянган/ төгрөгийн дэмжлэг үзүүлэн хамтран ажиллаа.



2020 оны жилийн төсөв, 2021 оны жилийн төсвийн төсөл, төсөвт орсон нэмэлт өөрчлөлтийн талаарх мэдээллийг www.sport.ub.gov.mn сайтад байршуулж нээлттэй мэдээлэн ажилласан.

Авлигын эсрэг хууль, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Нийслэлийн төлөвлөгөөг www.sport.ub.gov.mn сайтад байршуулсан.

Байгууллагын бүтэц, үйл ажиллагаа, орон тооны талаарх мэдээллийг www.sport.ub.gov.mn сайтад байршуулсан.

Иргэд хүлээн авах хуваарийн дагуу 5 иргэнийг хүлээн авч уулзсан. Мэдээ тайланг улирал бүр гарган Нийслэлийн Нэгдсэн үйлчилгээний төв болон Нийслэлийн засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэст хүргүүлж ажилласан.

“Удирдлагын академи”-ийн мэргэшүүлэх сертификаттай онлайн сургалтад хэлтсийн дарга-2, мэргэжилтэн-2 Төрийн албаны зөвлөлийн төлөвлөгөөт сургалтад дарга-1, мэргэжилтэн-1, Нийлэлийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан 4 удаагийн сургалтад дарга- 3, мэргэжилтэн-4 нийтдээ 12 удаагийн сургалтад давхардсан тоогоор 13 албан хаагчийг хамруулсан байна.

2020 онд манай байгууллагаас Ерөнхий боловсролын сургуулийн багш, арга зүйч, Цэцэрлэгийн багш арга зүйчдэд зориулсан “Хөдөлгөөн-Эрүүл мэнд” сэдэвт 2 удаагийн сургалтыг зохион байгуулж 200 байгууллагын 320 багш, арга зүйч, Аэробик болон хийн дасгалын сургалтыг 8 дүүргийн 93 хорооны 634 иргэдийг тус тус хамруулж улсын төсвөөс нийтдээ 6.760.000 төгрөг зарцуулсан.

НИЙСЛЭЛИЙН СПОРТЫН ХОРООНЫ ХҮНИЙ НӨӨЦИЙГ ЧАДАВХЖУУЛАХ,
НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАЖ, ТОГТВОР СУУРЬШИЛТАЙ АЖИЛЛУУЛАХ
2020 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЖИЛИЙН ЭЦСИЙН БИЕЛЭЛТ

2020 оны 12 дугаар сарын 20

Улаанбаатар хот

Зорилт	№	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Зүрилтот түвшин (Тоо хэмжээ, хувь)	Хүрсэн түвшин (Хэрэгжилт ийн хувь, тоо хэмжээ)	Зарцуулсан хөрөнгө, эх үүсвэр гүйцэтгэлээр (мян.төг)	Тайлбар
1. Хүний нөөцийг чадавхжуулах	1.	Албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан гадаад, дотоодын сургалт	Дотоод сургалтын тоо	5-аас дээш	5 буюу 100%	6.760.000	2020 онд манай байгууллагаас Ерөнхий боловсролын сургуулийн багш, арга зүйч, Цэцэрлэгийн багш арга зүйчдэд зориулсан “Хөдөлгөөн-Эрүүл мэнд” сэдэвт 2 удаагийн сургалтыг зохион байгуулж 200 байгууллагын 320 багш, арга зүйч, Аэробик болон хийн дасгалын сургалтыг 8 дүүргийн 93 хорооны 634 иргэдийг тус тус хамруулан зохион байгуулсан. Түүнчлэн салбарын хэмжээнд зохион байгуулсан “Хууль эрх зүй”, “Цахим мэдээллийн системийн хэрэглээ” сэдэвт 2 удаагийн онлайн сургалтад нийслэл дүүргийн спортын хороодын давхардсан тоогоор 60 гаруй албан хаагчийг хамрууллаа.
			Албан хаагчдын хамрагдсан байдал	80 хувиас дээш	100%	-	“Удирдлагын академи”-ийн мэргэшүүлэх сертификаттай онлайн сургалтад хэлтсийн дарга-2, мэргэжилтэн-2 Төрийн албаны зөвлөлийн төлөвлөгөөт сургалтад дарга-1, мэргэжилтэн-1, Нийлэлийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан 4 удаагийн сургалтад дарга- 3, мэргэжилтэн-4 нийтдээ 12 удаагийн сургалтад давхардсан тоогоор 13 албан хаагчийг хамруулсан болно.

		Гадаад сургалтад албан хаагчдын хамрагдсан байдал	20 хувиас дээш	Тооцох боломжгүй	-	Дэлхий дахинд тархаад байгаа Коронавирус /COVID-19/-ээс шалтгаалан гадаад дотоодын спортын арга хэмжээ, сургалт, дасгалжуулалт хаагдсантай холбоотойгоор гадаад сургалтад хамрагдаагүй.	
	2.	Мэргэшсэн, туршлагатай хүний нөөцийг бүрдүүлэх	3 болон түүнээс дээш жил ажилласан мэргэшсэн боловсон хүчний үзүүлэлт	70 хувиас дээш	90%	-	Нийт ажиллаж байгаа албан хаагчийн орон тоо 11 үүнээс 3-аас дээш жил ажилласан мэргэшсэн боловсон хүчний тоо 10, хүрсэн түвшин 90 хувьтай байна
Хэсгийн дундаж: 96%					6.760.000		
2. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах	3.	Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	Шагнал, урамшуулалд хамрагдсан албан хаагчдын тоо	Гүйцэтгэлээр	100%	12.323.852	Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/342, А/747 дугаар захирамжийн дагуу 2019 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийг хүртэл Сонгинохайрхан дүүргийн 27 дугаар хорооны айл өрхөд Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангах, сайжруулсан түлшний зөв хэрэглээг нэвтрүүлэх, заавар зөвлөмж хүргэх, 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдрөөс 2020 оны 06 дугаар сарын 05-ныг дуустал дэлхий нийтийг хамарсан шинэ төрлийн Коронавирус /COVID-19/ гарч халдвараас иргэд, олон нийтийг хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор улсын хэмжээнд онцгой дэглэм тогтоосонтой холбогдуулан Баянгол дүүргийн 11, 23 дугаар хорооны нутаг дэвсгэрт болзошгүй эрсдэлээс сэрэмжлүүлэх, ариутгал халдваргүйтгэлийн ажлыг тогтмол хийлгэх, иргэдийн хөл хөдөлгөөнийг хязгаарлахад хяналт тавих үйл ажиллагаанд байгууллагын бүх албан хаагчид хуваарийн дагуу эргүүл хяналтыг үр дүнтэй зохион байгуулж гүйцэтгэсэн тул албан хаагч бүрт нэг сарын үндсэн цалинтай тэнцэх урамшууллыг байгууллагын даргын 2020 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн А/09 дугаар тушаалаар 5.703.362 төгрөг, 2020 оны 06 дугаар сарын 04-ний

						өдрийн А/16 дугаар тушаалаар 6.620.490 төгрөгийн урамшууллыг тус тус олгосон.
		Албан хаагчдын үйл ажиллагааны үнэлгээ, ажилласан жил, ур чадварыг харгалзан олгох нэмэгдэл, зэрэг дэв, шатлал ахиулах	Гүйцэтгэлээр	100%	9.848.938	Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг улирал бүр үнэлж хангалттай үнэлэгдсэн нэгдүгээр улиралд 7, хоёрдугаар улиралд 7, гуравдугаар улиралд 7, дөрөвдүгээр улиралд 9 албан хаагчдад тус тус урамшуулал цалинг олгосон. 5 албан хаагчийн цалингийн шатлалыг нэг шатаар ахиулж ажиллаа.
4.	Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлсэн байдал	Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулга	Сэтгэл ханамж 80 хувиас дээш	100%	-	Албан хаагчдаас ажлын байрны таатай орчин сэтгэл ханамжийн судалгааг 5 асуулгын дагуу 2 удаа авч сэтгэл ханамж 100%-тай үнэлэгдсэн.
		Албан хаагчдад сар бүр олгох хоол, унааны зардлыг нэмэгдүүлэх	Гүйцэтгэлээр	100%	13.314.000	Албан хаагчдад өдрийн хоолны зардлыг 5000 төгрөгөөр тооцож жилийн эцэст 11.760.000, унааны зардлыг өдрийн 500 төгрөгөөр тооцож жилийн эцэст 1.554.000 төгрөгийг тус тус олгож ажилласан байна.
5.	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг	Жилд 1-ээс доошгүй удаа	Тооцох боломжгүй	-	Дэлхий нийтэд тархаад байгаа “Covid-19” цар тахал буюу коронавирусаас урьдчилан сэргийлэх зорилгоор гаргасан Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн “Шинэ коронавирусийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 30 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2020 оны “Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” А/108 дугаар захирамжийн хүрээнд эрүүл мэндийн үзлэгийг 4 дүгээр улиралд зохион байгуулахаар төлөвлөсөн боловч Коронавирусын халдвар дахин дэгдсэнтэй холбоотойгоор Засгийн Газрын 2020 “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай” 159, “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт

						шилжүүлэх тухай” 178, тогтоолууд, Улсын онцгой комиссын 2020 оны 34 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2020 оны “Коронавируст /Ковид-19/ цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай” А/1241, Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай А/1242 дугаар захирамж, Эрүүл мэндийн яамны зөвлөмжийн дагуу онц шаардлагагүй тохиолдолд эмнэлгийн байгууллагаар үйлчлүүлэхгүй байх тухай өвлөмжийн хүрээнд албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт үзлэгт хамруулаагүй болно.
		Албан хаагчдын хамрагдалт	100 хувь	60%	-	Байгууллагын 6 албан хаагч биеийн эрүүл мэндийн зайлшгүй шалтгаанаа тодорхойлох зорилгоор өөрийн хүсэлтээр эрүүл мэндийн үзлэг оншилгоонд хамрагдсан байна.
Хэсгийн дундаж: 92%					35.486.790	
Үнэлгээний дундаж хувь:94%					42.247.287	

**2020 оны жилийн эцсийн үйл ажиллагааг явуулахад гарсан хүндрэл бэрхшээл,
цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ**

Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/241 дүгээр захирамжаар манай байгууллагын бүтэц орон тооны хязгаарыг 16 албан хаагчтай байхаар баталсан.

Одоогоор 11 хүний бүрэлдэхүүнтэй үйл ажиллагаа явуулж байна.

Төрийн албаны нөөцөд ажлын байрны шалгуурыг хангасан иргэн байхгүй учраас сул орон тоог нөхөн боломжгүй байгаа тул ажлын ачаалал их байна.

Дэлхий нийтэд тархаад байгаа “Covid-19” цар тахал буюу коронавирусын улмаас жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг томоохон спортын арга хэмжээнүүд тасалдаж, иргэдийн спортоор хичээллэх орчин нөхцөл, заал танхим нээгдээгүй нь улмаас нийслэлийн иргэд хөдөлгөөны дутагдалд орж эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх асуудал тулгараад байна.

Нийслэл, Найлайх, Баянзүрхийн Спорт цогцолборын барилгын ажлын төсвийг 2020 оны улсын төсөвт тусгаагүй тул барилгын ажлын явц бүрэн зогссон.

Тус спортын цогцолборын барилгын ажлыг гүйцэтгэх төсвийг 2021 оны төсвийн тодотгол буюу 2022 оны төсвийн төсөлд суулгаж барилгын ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байна.

ХЯНАСАН:

НИЙСЛЭЛИЙН СПОРТЫН ХОРООНЫ
ДАРГА

Ж.ГАНБОЛД

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

ХҮНИЙ НӨӨЦ, ДОТООД АЖИЛ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

М.ЦОГЗОЛМАА